



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнзүйл сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны  
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын  
тайлан

Аудитын код: ӨВА-2026/07/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2026 он	Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: <a href="mailto:Batjargalo@audit.gov.mn">Batjargalo@audit.gov.mn</a> Аудитын менежер: П.Хорлоосүрэн Утас: 70323833 Цахим хаяг: <a href="mailto:Khorloosuren@audit.gov.mn">Khorloosuren@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг Утас: 70323108 Цахим хаяг: <a href="mailto:Erdenetsetsegb@audit.gov.mn">Erdenetsetsegb@audit.gov.mn</a> Аудитор: Ц.Мөнхзаяа Утас: 70323108 Цахим хаяг: <a href="mailto:Munkhzayats@audit.gov.mn">Munkhzayats@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3.Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	13
4.Аудитын тайлан.....	
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсарын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. Аудитын илрүүлэлт.....	
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНХС	Онон нүтгийн хөгжлийн сан
ЭХС	Эрсдэлээс хамгаалах сан
ОНЕО	Орон нүтгийн ерөнхий орлого
НББ	Нягтлан бодох бүртгэл
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
УТХ	Улсын тэмдэгтийн хураамж
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч



ЕСӨНЗҮЙЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ц.МЯГМАРСҮРЭН ТАНАА

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,  
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,  
Утас/Факс: (976) 7032 3253,  
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026. 03. 24 № 162

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Есөнзүйл сумын төсвийн Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайланд ЗДТГ, ИТХ, ОНХС, ХХС Орон нутгийн ерөнхий орлогын санхүүгийн тайлангууд, Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Цэцэрлэг, Соёлын төв зэрэг улсын төсөвт байгууллагуудад олгосон тогтмол зардал, урсгал засварын зардлын санхүүжилт нэгтгэгдсэн байна. Нэгтгэсэн санхүүгийн тайлангаар 3,439.8 сая төгрөгийн нийт хөрөнгө, 4,954.0 сая төгрөгийн орлого 4,219.5 сая төгрөгийн зардлыг тайлагнажээ.

**Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

**Бусад асуудал**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6225020376

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ